



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АРВАНТАВДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 17

Мөрөн сум

┌ **Д.Энхсүхийн цалин, нэмэгдлийг
шинэчлэн тогтоох тухай** ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2 дахь хэсэг, төсвийн тухай тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5,3, Улсын их хурлын 2007 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 73 дугаар тогтоол “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралт “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 23-р хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арвантавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1.Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулж Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Энхсүхэд 2,145,000 /Хоёр сая нэг зуун дөчин таван мянган/ төгрөгийн үндсэн цалин олгохыг зөвшөөрсүгэй

2. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (Д.энхсүх)-д хууль журмын дагуу албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30%, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40%-иар бодож үндсэн цалингаас тооцон олгохыг зөвшөөрсүгэй.

D:/Togtool.doc-2024

231300133

3.(Д.Энхсүх)-ийн үндсэн цалин, нэмэгдлийг зохих журмын дагуу бодож 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр тооцож олгохыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нягтлан бодогч (С.Энхсүх)- д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. ЭНХСҮХ